



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШТАР
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

дат. 01.09 № 31-1/06
танай _____ -ны № _____ -т

Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай

Төмөр замын тээврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт
оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн
шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024. 01. 09 № ХЭГ/57
танай -ны № -т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Д.ЭНХБАТ ТАНАА

Г Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Төмөр замын тээврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт
оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн
шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг
хүсье.

Хавсралт хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭС**

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэлд:

“ХIII.ХЭЛЭЛЦСЭН нь: Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.”

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.”
гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.01.05 № 1/45
танай 2023.12.27-ны № 01/6282 -т

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙД С.БЯМБАЦОГТ ТАНАА

Төмөр замын тээврийн тухай хууль болон
Иргэний нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах
тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай
хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны
дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл
олгож байна.



151605694
Doc.yam a5.2023



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл:info@mof.gov.mn
Вэбсайт:www.mof.gov.mn

2024. 01. 08 № 01/100
танай 23. 01. 17 -ны № 01/60182 -т


ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД С.БЯМБАЦОГТ ТАНАА

Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай, Иргэний нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай болон Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгож байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761000027



ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл шаардлага

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан бөгөөд уг хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь төмөр замын тээврийн үйл ажиллагаатай холбоотой хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байна” гэж заасан байна.

Монгол Улсын Их Хуралд 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр өргөн барьсан Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд Монгол Улсын төсөвт 2024 оны төвлөрүүлэх орлого, зарлагын бүрэлдэхүүнд Засгийн газрын тохируулагч агентлаг “Иргэний нисэхийн ерөнхий газар” Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Төмөр замын газар” байгуулах асуудал тусгагдаагүй болно.

Үүнтэй уялдуулан Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны 48 дугаар тэмдэглэлд “Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайдад даалгасан” болно.

Иймд Төмөр замын тээврийн тухай хуульд заасан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төмөр замын газар нь 2024 онд байгуулагдахгүй болсон тул Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага үүсээд байна.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үйлчлэх хугацааг өөрчлөх 1 заалттай болно.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар Төмөр замын тээврийн тухай хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх нөхцөл бүрдэх бөгөөд улмаар улсын төсвийг үр нөлөөтэй оновчтой төлөвлөх, хуваарилах асуудал шийдвэрлэгдэх юм.

Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуулттай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Энэ хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцүүлэн боловсруулна.

Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Төмөр замын тээврийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

УИХ-ын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан бөгөөд уг хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь төмөр замын тээврийн үйл ажиллагаатай холбоотой хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байна” гэж заасан.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд Монгол Улсын төсөвт 2024 оны төвлөрүүлэх орлого, зарлагын бүрэлдэхүүнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Төмөр замын газар” байгуулах асуудал тусгагдаагүй болно.

Үүнтэй уялдуудан Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны 48 дугаар тэмдэглэлд “Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайдад даалгасан” болно.

Иймд Төмөр замын тээврийн тухай хуульд хуульчилсан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төмөр замын газар нь 2024 онд байгуулагдахгүй болсон тул Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага үүссэн болно.

Хуулийн төслийн зорилго нь Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагаж мөрдөх хугацааг өөрчлөхтэй холбоотой болно.

Хуулийн төсөл нь Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үйлчлэх хугацааг өөрчлөх 1 заалттай бөгөөд шинээр нэр томьёо тусгаагүй болно.

Төмөр замын тээврийн тухай хуулийг 2007 оноос өнөөг хүртэл мөрдөж байгаа болно.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн хуулийн төслийн үзэл баримтлалын хамт боловсруулан, төрийн захиргааны төв байгууллагуудаас санал авч, Засгийн хуралдаанаар хэлэлцүүлсэн болно.

Хуулийн төсөл батлагдсанаар Төмөр замын тээврийн тухай хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх нөхцөл бүрдэх бөгөөд улмаар улсын төсвийг үр нөлөөтэй оновчтой төлөвлөх, хуваарилах асуудал шийдвэрлэгдэх юм.

Энэ хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцүүлэн боловсруулна.

Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Төмөр замын тээврийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

ТАНИЛЦУУЛГА

Төмөр замын тээврийн тухай хуульд
/Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт
оруулах тухай хуулийн төслийн талаар

УИХ-ЫН 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар Төмөр замын тээврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ болон Төмөр замын тээврийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулИЙГ тус тус баталсан.

Төмөр замын тээврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь төмөр замын тээврийн үйл ажиллагаатай холбоотой хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байна.” гэж заасан.

Уг агентлаг нь төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд суурь бүтэц эзэмшигчийн хооронд, суурь бүтэц эзэмшигч болон тээвэрлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, галт тэрэгний хөдөлгөөнийг захирамжлан зохион байгуулах чиг үүрэгтэй төрийн захиргааны байгууллага юм.

Гэвч Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд Монгол Улсын төсөвт 2024 оны төвлөрүүлэх орлого, зарлагын бүрэлдэхүүнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Төмөр замын газар” байгуулах асуудал тусгагдаагүй болно.

Иймд дээрх агентлаг нь 2024 онд байгуулагдахгүй болсон тул Төмөр замын тээврийн тухай хуулийн хүчин төгөлдөр болох хугацааг “2024 оны 01 дүгээр сарын 01-ний” гэснийг “2025 оны 01 дүгээр сарын 01-ний” гэж, Төмөр замын тээврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “2023 оны 12 дугаар сарын 31-ний” гэснийг “2024 оны 12 дугаар сарын 31-ний” гэж, 5 дугаар зүйлийн “2024 оны” гэснийг “2025 оны” гэж тус тус өөрчлөх саналыг танилцуулж байна.

Хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20 ... оны ... сарын ... өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-Д ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгийн “2024 оны 01 дүгээр сарын 01-ний” гэснийг “2025 оны 01 дүгээр сарын 01-ний” гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20 ... оны ... сарын ... өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн "2023 оны 12 дугаар сарын 31-ний" гэснийг "2024 оны 12 дугаар сарын 31-ний" гэж, 5 дугаар зүйлийн "2024 оны" гэснийг "2025 оны" гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг